БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2022/22/НА-СТА-ТШЗ**


Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цээням

Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Азбаяр

Утас: 99061429 Цахим хаяг: azbayarb@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn



Баянхонгор
2022 он


005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## Агуулга


2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ..... 4

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/ ..... 4

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/ ..... 5

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/ ..... 6

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/ ..... 8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/ ..... 8

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/ ..... 10

3. Аудитын тайлан ..... 11

3.1 Ерөнхий зүйл ..... 11

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ..... 11

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 12

3.4 Материаллаг байдал ..... 12

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ..... 12

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 13

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ..... 14

3.8 Аудитын гол асуудал ..... 14

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 15

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 15

3.9.2 Засгийн "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт ..... 16

3.9.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд ..... 16

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 16

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 16

4. Аудитын илрүүлэлт ..... 16

4.1 Зөвлөмж ..... 17

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ..... 18


### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.25 № 2/139

танай ______________ -ны № ______________ -т

БАЯНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА М.ЧИНБАТ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянцагаан сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол дагуу Баянхонгор сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Аудитын гол асуудал**

Баянцагаан сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшнээс давсан, мөн АДБОУС 1240 (АОУС 240) дагуу сонгосон горим сорилоор доорх алдаа зөрчил илэрсэн нь “Хязгаарлалттай” дүгнэлт өгөх үндэслэл болно.

- Тайлант онд шилжиж ирсэн 25.0 сая төгрөгийн үнэ бүхий Лексус-470 маркийн автомашин нь банк бус санхүүгийн байгууллагын нэр дээр эзэмшлийн гэрчилгээтэй.

005020290

- Өмнөх онд зөвлөмжөөр хөрөнгө оруулалтаар ирээд 3 жил болоогүй TLC 200 автомашин засвар үйлчилгээ, зогсоолын төлбөр 8,149.9 мянган төгрөгийг төсвөөс гаргасанд төсөвт буцаан төлүүлж төсөвт учирсан хохирлыг арилгахаар өгсөн зөвлөмж хэрэгжүүлээгүй,
- Тайлант онд шилжиж ирсэн, өөрийн эзэмшилд шилжээгүй дээрх Лексус-470 автомашинд 7,000.0 мянган төгрөгийн засвар хийсэн.

Дээрх нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5.1-д заасан "Төрийн өөрийн өмчид энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад төр эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулж болох дараах эд хөрөнгө хамаарна:", “төрийн байгууллага, албан газарт эзэмшүүлсэн эд хөрөнгө” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн “Оршин буй байдал”, батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

D:\Alban bichig\A4-toot.docx

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/ 2021.12.31

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **20,215,755.94** | **35,364,663.00** |
| **33** | **АВЛАГА** | 00.00 | 22,971,260.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 00.00 | 615,010.00 |
| **335** | **Бусад авлага** | 00.00 | 22,356,250.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 00.00 | 11,000,000.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 00.00 | 11,356,250.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 20,215,755.94 | 12,393,403.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 1,688,000.00 | 1,688,000.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 1,688,000.00 | 1,688,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 6,145,403.00 | 5,205,403.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 903,600.00 | 1,793,300.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 5,241,803.00 | 3,412,103.00 |
| 35600 | Мал амьтад | 12,382,352.94 | 5,500,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,290,850,055.97** | **1,314,567,839.56** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,290,850,055.97 | 1,314,567,839.56 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,276,950,055.97 | 1,300,667,839.56 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,121,329,637.10 | 2,125,479,637.10 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -1,185,558,746.35 | -1,245,506,681.93 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 155,334,244.68 | 190,934,244.68 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -88,485,111.52 | -64,990,312.12 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 107,021,670.80 | 123,645,740.80 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -59,260,369.95 | -63,247,087.45 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 36,091,519.82 | 35,187,249.82 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -21,864,289.09 | -24,557,701.72 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 304,959,173.00 | 320,781,703.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -93,358,962.52 | -97,800,242.62 |
| 39217 | Ном | 741,290.00 | 741,290.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 13,900,000.00 | 13,900,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 14,375,000.00 | 14,375,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | -475,000.00 | -475,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,311,065,811.91** | **1,349,932,502.56** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **00.00** | **11,356,250.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 00.00 | 11,356,250.00 |
| **413** | **Өглөг** | 00.00 | 11,356,250.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 00.00 | 11,356,250.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 00.00 | 11,356,250.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,311,065,811.91** | **1,338,576,252.56** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,311,065,811.91 | 1,338,576,252.56 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 398,727,817.78 | 398,727,817.78 |
| 51101 | Өмч: - төрийн | 398,727,817.78 | 398,727,817.78 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 700,841,590.89 | 728,352,031.54 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 700,841,590.89 | 700,841,590.89 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 27,510,440.65 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 211,496,403.24 | 211,496,403.24 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,311,065,811.91** | **1,349,932,502.56** |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/ 2021.12.31

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **669,375,671.16** | **673,745,654.88** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **244,688,936.80** | **230,768,980.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 244,688,936.80 | 230,768,980.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 244,688,936.80 | 679,980.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 507,900.00 | 679,980.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 244,181,036.80 | 00.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй авсан бараа материал | | 53.010.800.00 |
| 120017 | үнэ төлбөргүй авсан үндсэн хөрөнгө | | 177.078.200.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **424,686,734.36** | **442,976,674.88** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 16,515,388.00 | 34,041,212.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 12,000,000.00 | 34,041,212.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 4,515,388.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 408,171,346.36 | 408,935,462.88 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 408,171,346.36 | 408,935,462.88 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **553,873,605.72** | **608,342,317.36** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **553,873,605.72** | **608,342,317.36** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 536,481,685.36 | 587,039,431.20 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 217,972,264.00 | 209,861,660.31 |
| 210101 | Үндсэн цалин | 217,972,264.00 | 209,861,660.31 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 28,426,603.83 | 27,705,139.41 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,708,065.83 | 19,369,306.65 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,178,410.00 | 2,083,957.44 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,742,440.00 | 1,667,169.07 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 435,619.00 | 416,788.37 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,362,069.00 | 4,167,917.88 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 27,500,230.00 | 26,476,176.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,138,066.00 | 7,439,367.00 |
| 210302 | Түлш, халаалт | 19,362,164.00 | 19,036,809.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 61,216,735.88 | 115,508,566.94 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,790,060.00 | 2,938,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 19,601,170.00 | 21,428,155.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 656,700.00 | 849,960.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 5,240,100.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 346,000.00 | 27,119,299.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 600,000.00 | 600,000.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 30,982,705.88 | 9,561,852.94 |
| 210409 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/ | 00.00 | 53,010,800.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 14,515,000.00 | 20,408,100.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 850,000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 13,665,000.00 | 20,408,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 5,319,000.00 | 4,765,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,319,000.00 | 4,765,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 51,066,047.00 | 39,671,529.00 |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 005 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 46,624,933.00 | 34,771,108.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 500,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 593,450.00 | 562,590.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 179,500.00 | 99,050.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 24,908.00 | 102,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,564,000.00 | 3,564,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 79,256.00 | 72,781.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 130,465,804.65 | 142,642,759.54 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 19,455,000.00 | 23,975,240.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,199,450.00 | 00.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 109,811,354.65 | 118,667,519.54 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 17,391,920.36 | 21,302,886.16 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 990,000.00 | 1,500,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 990,000.00 | 1,500,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 16,401,920.36 | 19,802,874.16 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 16,401,920.36 | 19,802,874.16 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 12.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **115,502,065.44** | **65,403,337.52** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 2,144,444.37 | 37,892,896.87 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 2,144,444.37 | 37,892,896.87 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -2,144,444.37 | -37,892,896.87 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **113,357,621.07** | **27,510,440.65** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/ 2021.12.31

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **425,194,634.36** | **443,656,654.88** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **507,900.00** | **679,980.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 507,900.00 | 679,980.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 507,900.00 | 679,980.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 507,900.00 | 679,980.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **424,686,734.36** | **442,976,674.88** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 16,515,388.00 | 34,041,212.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 12,000,000.00 | 34,041,212.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 4,515,388.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 408,171,346.36 | 408,935,462.88 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 408,171,346.36 | 408,935,462.88 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **414,444,634.36** | **440,456,654.88** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **414,444,634.36** | **440,456,654.88** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **397,052,714.00** | **419,153,768.72** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 217,764,320.00 | 210,476,670.31 |
| 210101 | Үндсэн цалин | 217,764,320.00 | 210,476,670.31 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 27,832,099.00 | 27,705,139.41 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАГДМАЛ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,113,561.00 | 19,369,306.65 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,178,410.00 | 2,083,957.44 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,742,440.00 | 1,667,169.07 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 435,619.00 | 416,788.37 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,362,069.00 | 4,167,917.88 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 27,500,230.00 | 26,476,176.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,138,066.00 | 7,439,367.00 |
| 210302 | Түлш, халаалт | 19,362,164.00 | 19,036,809.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 31,868,970.00 | 53,707,614.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,945,060.00 | 3,470,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 19,601,170.00 | 21,668,155.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,136,640.00 | 849,960.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 6,240,100.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 346,000.00 | 27,119,299.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 600,000.00 | 600,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 14,915,000.00 | 22,375,900.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 850,000.00 | 00.00 |
| 210602 | Тавилга | 400,000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 13,665,000.00 | 22,375,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 5,319,000.00 | 4,765,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,319,000.00 | 4,765,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 52,098,645.00 | 39,671,529.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 47,657,531.00 | 34,771,108.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 500,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 593,450.00 | 562,590.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 179,500.00 | 99,050.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 24,908.00 | 102,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,564,000.00 | 3,564,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 79,256.00 | 72,781.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 19,754,450.00 | 33,975,240.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 18,555,000.00 | 33,975,240.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,199,450.00 | 00.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **17,391,920.36** | **21,302,886.16** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 990,000.00 | 1,500,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 990,000.00 | 1,500,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 16,401,920.36 | 19,802,886.16 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 16,401,920.36 | 19,802,874.16 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **10,750,000.00** | **3,200,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **10,750,000.00** | **3,200,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **10,750,000.00** | **3,200,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 10,750,000.00 | 3,200,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 10,750,000.00 | 3,200,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-10,750,000.00** | **-3,200,000.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/ 2021.12.31

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **398,727,817.78** | **211,496,403.24** | **700,841,590.89** | **00.00** | 1,311,065,811.91 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **398,727,817.78** | **211,496,403.24** | **700,841,590.89** | **00.00** | 1,311,065,811.91 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **398,727,817.78** | **211,496,403.24** | **700,841,590.89** | **00.00** | 1,311,065,811.91 |
| D01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **398,727,817.78** | **211,496,403.24** | **700,841,590.89** | **00.00** | 1,311,065,811.91 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **398,727,817.78** | **211,496,403.24** | **700,841,590.89** | **00.00** | 1,311,065,811.91 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 27,510,440.65 | 00.00 | 27,510,440.65 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **398,727,817.78** | **211,496,403.24** | **728,352,031.54** | **00.00** | 1,338,576,252.56 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/ 2021.12.31

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 410,935,462.88 | 389,812,568.72 | (21,122,894.16) | 94.9 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 410,935,462.88 | 389,812,568.72 | (21,122,894.16) | 94.9 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 409,435,462.88 | 388,312,568.72 | (21,122,894.16) | 94.8 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 226,687,475.00 | 210,476,670.31 | (16,210,804.69) | 92.8 |
| 210101 | Үндсэн цалин | 226,687,475.00 | 210,476,670.31 | (16,210,804.69) | 92.8 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 30,602,765.00 | 27,705,139.41 | (2,897,625.59) | 90.5 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,530,471.00 | 19,369,306.65 | (2,161,164.35) | 90.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,266,877.00 | 2,083,957.44 | (182,919.56) | 91.9 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,813,765.00 | 1,667,169.07 | (146,595.93) | 91.9 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 457,780.00 | 416,788.37 | (40,991.63) | 91.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,533,872.00 | 4,167,917.88 | (365,954.12) | 91.9 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 26,537,047.00 | 26,476,176.00 | (60,871.00) | 99.8 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,493,909.00 | 7,439,367.00 | (54,542.00) | 99.3 |
| 210302 | Түлш, халаалт | 19,043,138.00 | 19,036,809.00 | (6,329.00) | 100.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 53,999,103.00 | 53,707,614.00 | (291,489.00) | 99.5 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,523,865.00 | 3,470,200.00 | (53,665.00) | 98.5 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 21,441,850.00 | 21,668,155.00 | 226,305.00 | 101.1 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,273,388.00 | 849,960.00 | (423,428.00) | 66.7 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 27,160,000.00 | 27,119,299.00 | (40,701.00) | 99.9 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 600,000.00 | 600,000.00 | - | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 25,591,662.88 | 25,575,900.00 | (15,762.88) | 99.9 |
| 210602 | Тавилга | 700,000.00 | 700,000.00 | - | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 24,891,662.88 | 24,875,900.00 | (15,762.88) | 99.9 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 6,280,910.00 | 4,765,500.00 | (1,515,410.00) | 75.9 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,280,910.00 | 4,765,500.00 | (1,515,410.00) | 75.9 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5,736,500.00 | 5,630,329.00 | (106,171.00) | 98.1 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 659,800.00 | 729,908.00 | 70,108.00 | 110.6 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | 500,000.00 | - | 100.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 600,000.00 | 562,590.00 | (37,410.00) | 93.8 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 180,000.00 | 99,050.00 | (80,950.00) | 55.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 102,000.00 | 102,000.00 | - | 100.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,564,000.00 | 3,564,000.00 | - | 100.0 |
| 210807 | Газрын төлбөр | 130,700.00 | 72,781.00 | (57,919.00) | 55.7 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 34000000.00 | 33975240.00 | (24,760.00) | 99.9 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 34,000,000.00 | 33,975,240.00 | (24,760.00) | 99.9 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1500000.00 | 1500000.00 | - | 100.0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,500,000.00 | 1,500,000.00 | - | 100.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,500,000.00 | 1,500,000.00 | - | 100.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 410,935,462.88 | 389,812,568.72 | (21,122,894.16) | 94.9 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 408,935,462.88 | 389,132,588.72 | (19,802,874.16) | 95.2 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 408,935,462.88 | 389,132,588.72 | (19,802,874.16) | 95.2 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 2,000,000.00 | 679,980.00 | (1,320,020.00) | 34.0 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,000,000.00 | 679,980.00 | (1,320,020.00) | 34.0 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 13 | 13 | - | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 01 | 01 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 07 | 07 | - | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 05 | 05 | - | 100.0 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **07** | **07** | - | 100.0 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 07 | 07 | - | 100.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/ 2021.12.31

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **16,515,388.00** | **34,041,200.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **16,515,388.00** | **34,041,200.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 16,515,388.00 | 34,041,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 16,515,388.00 | 34,041,200.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 16,515,388.00 | 34,041,200.00 |
| II | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 16515388.00 | 34041200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 16,515,388.00 | 34,041,200.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 12,000,000.00 | 34,041,200.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 4,515,388.00 | 00.00 |
| IV | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | **0.00** | **0.00** |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 0.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 0.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цэзням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт төсвийн гүйцэтгэлийн аудит хийлгэх хүсэлтийг 2022 оны 01 дүгээр сарын 13-ний өдөр ирүүлсэн байна.

Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах эрхийн 1 дүгээр гарын үсгийг ЗДТГ-ын дарга М.Чинбат, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Г.Түмэнболд нар зурсан байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газрын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

**Зорилго**: Засаг даргаас хуулиар тогтоосон бүрэн эрх, төрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахад ажлын албыг удирдлага чиг үүргээр хангаж, засаг даргын цаг үеэ олсон мэргэжлийн зөвлөгөө мэдээллээр хангаж, сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлэх, төрийн хууль тогтоомж шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, мэдээлж сурталчлах, байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг шуурхай, шударга хүргэх

**Чиг үүрэг:** Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.1-67.1.8-д заасан чиг үүргийн хэрэгжүүлнэ. Төр,эдийн засаг, нийгмийн бодлогын удирдлагын үйл ажиллагаа

- Засаг даргын үнэн зөв мэдээллээр хангаж шийдвэр гаргахад нь дэмжлэг үзүүлж, бүрэн эрхийн хугацааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг шуурхай зохион байгуулна.
- Нутгийн захиргааны зохион байгуулалтыг боловсронгуй болгож,ажлын уялдаа холбоог сайжруулж төрийн үйлчилгээг улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүйгээр хөнгөн шуурхай, шударга явуулж хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангах.
- Сумын тогтвортой хөгжлийн бодлогыг тодорхойлж, байгаль орчныг хамгаалах, орчны бохирдлыг бууруулах, ард иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүү, хяналт аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 553,873.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 5,538.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 3,877.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 4,258.4 мянган төгрөг байгаа тул төлөвлөлтийн үе шатны материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 38,866.7 мянган

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 005 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

төгрөгөөр буюу 2.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| А | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 20,215.8 | 35,364.7 | 15,148.9 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | - | 22,971.3 | 22,971.3 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 20,215.8 | 12,393.4 | (7,822.4) |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,290,850.1 | 1,314,567.8 | 23,717.8 |
| Үндсэн хөрөнгө | 2,739,852.5 | 2,811,144.9 | 71,292.3 |
| Хуримтлагдсан элэгдэл | (1,449,002.5) | (1,496,577.0) | (47,574.5) |
| **Нийт хөрөнгө** | 1,311,065.8 | 1,349,932.5 | 38,866.7 |
| Өр төлбөр | - | 11,356.3 | 11,356.3 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,311,065.8 | 1,338,576.3 | 27,510.4 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 1,311,065.8 | 1,349,932.5 | 38,866.7 |

Авлагын данс дансны үлдэгдэл өмнөх онд үлдэгдэлгүй байсан бол тайлант онд 22,971.3 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь сумын ЗДТГ-ын шинэ барилгын 11,000.0 төгрөгийн зураг, төсвийн үнэ, 11,356.0 мянган төгрөгийн өвс тэжээлийн авлага туссантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 12,393.4 мянган төгрөг болж 7,822.4 мянган төгрөгөөр буурсан нь аж ахуйн материал 1,829.7 мянга, мал амьтад 6,882.4 мянган төгрөгөөр хорогдсон нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,811,144.9 мянган төгрөг болж 71,292.3 мянган төгрөгөөр өссөн нь 6,650.0 мянган төгрөгийн хашааг бараа материалын данснаас үндсэн хөрөнгөд шилжүүлэн бүртгэсэн, аймгийн ИТХ-ын 2021 оны 20 дугаар тогтоолоор 25,000.0 мянган төгрөгийн Lexus-470 автомашин, ОНХС-гийн хөрөнгөөр 34,000.0 мянган төгрөгөөр бохир соруулах машин, 55,000.0 мянган төгрөгөөр ковш үнэ хүлээн авсан, машин тоног, төхөөрөмжийн дансанд ОНХС-гийн хөрөнгөөр 9,800.0 мянга, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 9700.0 мянган төгрөгийн ухаалаг худаг, ОНХС-гийн хөрөнгөөр 20,000.0 мянган төгрөгийн хөргүүртэй контейнер, 9,900.0 мянган төгрөгөөр мал угаалгын ванн худалдан авсантай холбоотой байна. Мөн тайлант онд аймгийн ИТХ-ын 2021 оны 20 тоот тогтоолоор 59,800.0 мянган төгрөгөөр ланд-200 автомашиныг шилжүүлсэн, ИТХ-ын 2021 оны 156 дугаар тогтоолоор 48,668.0 мянган төгрөгийн хөрөнгө акталсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,338,576.3 мянган төгрөг болж 38,866.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 443,127.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 79,980.6 мянган төгрөгөөр бууруулж 363,147.2 мянган төгрөгөөр анх батлагдсан байна. Санал хүргүүлсэн зардлаас цалингийн зардлыг 19,256.5 мянга, ЭМНДШ-ийг 2,599.6 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 13,362.3 мянган төгрөгөөр тус тус бууруулан баталсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 410,935.4 мянган төгрөгийн төсөв баталсныг орон нутгийн төсвөөс 408,935.4 мянга, өөрийн орлогоор 2,000.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна .

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 408,935.4 мянган төгрөгийн санхүүжилт авч өөрийн орлогоор 680.0 мянган төгрөгийг төвлөрүүлэн, 389,812.5 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст 19,802.9 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 389,812.5 мянган төгрөг буюу 94.9 хувьтай байгаа бөгөөд тайлант онд цалингийн зардал 16210.8 мянга, ЭМНДШ-ийн зардал 2,897.6 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 60.9 мянга, томилолтын зардал 1,515.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь нөлөөлсөн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тухайн байгууллага нь 2021 онд нэмэлт санхүүжилтийн дансаар Статистикийн хэлтсээс тооллогын зардалд 834.1 мянга, аймгийн ЗДТГ-аас өвс тээвэрлэлтийн зардалд 4,613.7 мянга, Бохирын автомашин худалдан авах зардалд 25,000.0 мянга, хамтарсан багийн зардалд 1,800.0 мянга, өвсний үнэд 1,350.0 мянга, сургалтын зардалд 443.4 мянган төгрөг төвлөрч 34,042.2 мянган төгрөгийг бүрэн зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Баянцагаан сумын ЗДТГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 99.0 хувьтай дүгнэсэн байна.

## 3.8 Аудитын гол асуудал

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 608,342.3 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 54,469.7 мянган төгрөгөөр буюу 9.8 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь хог хаях устгах, урсгал засвар, бараа үйлчилгээний бусад зардал, урсгал шилжүүлгийн зардлууд нь өмнөх оноос өссөн бол бусад зардлууд буурсан үзүүлэлттэй байна.

Баянцагаан сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшнээс давсан, мөн АДБОУС 1240 (АОУС 240) дагуу сонгосон горим сорилоор доорх алдаа зөрчил илэрсэн нь "Хязгаарлалттай" дүгнэлт өгөх үндэслэл болно.

- Тайлант онд шилжиж ирсэн 25,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий Лексус-470 маркийн автомашин нь банк бус санхүүгийн байгууллагын нэр дээр эзэмшлийн гэрчилгээтэй.

- Өмнөх онд зөвлөмжөөр хөрөнгө оруулалтаар ирээд 3 жил болоогүй TLC 200 автомашин засвар үйлчилгээ, зогсоолын төлбөр 8,149.9 мянган төгрөгийг төсвөөс гаргасанд төсөвт буцаан төлүүлж төсөвт учирсан хохирлыг арилгахаар өгсөн зөвлөмж хэрэгжүүлээгүй,

- Тайлант онд шилжиж ирсэн, өөрийн эзэмшилд шилжээгүй дээрх Лексус-470 автомашинд 7,000.0 мянган төгрөгийн засвар хийсэн.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд оруулбал зохих 493,678.8 мянган төгрөгийн үнийн дүнтэй 151 мэдээллийг байршуулахаас 402,170.6 мянган төгрөгийн 116 мэдээллийг хугацаанд нь байршуулсан бол Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 91,507.8 мянган төгрөгийн 35 мэдээг хугацаа хоцроож байршуулсан тул Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж байх зөвлөмжийг төсөв захирагчид өгөв.

Харин 2 мэдээлэл байршуулах хугацаа болоогүй байна.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| д/д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд байршуулсан | Хугацаа хоцроож байршуулсан | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 6 | 3 | 2 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 3 | 1 | 0 |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 3 | 1 | 0 |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 28 | 8 | 0 |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 74 | 22 | 0 |
| 6 | Нийт | 27 | 151 | 114 | 35 | 2 |

### 3.9.2 Засгийн "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалтад тогтоолын хэрэгжилтийг шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

- Тайлант онд 410,935.4 мянган төгрөгийн төсөв зарцуулахаар батлагдаж гүйцэтгэлээр 389,812.6 мянган төгрөгийг зарцуулж, 21,122.9 мянган төгрөг буюу 5.1 хувийг хэмнэсэн байна.
- Албан томилолтын зардлыг 6,280.9 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 4,765.5 мянган төгрөг зарцуулж 1,515.4 мянган төгрөг хэмнэжээ.
- Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 26,986.1 мянган төгрөгөөр, тодотголоор 26,537.0 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 26,476.2 мянган төгрөг зарцуулж, анх баталсан дүнгээс 2,509.9 мянган төгрөг буюу 1.8 хувь хэмнэсэн нь ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 20 хувь бууруулж хэмнэх дээрх тогтоолын 1.8 дах заалтыг хэрэгжүүлээгүй байна.

### 3.9.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, тайлант хугацаанд ЕБС-ийн хүнс, болон үдийн цайны зардалд худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 31,682.7 мянган төгрөгийн төгрөгийн хөрөнгөтэй холбоотой 1, арвилан хэмнэлт үр ашигтай холбоотой 1, Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 нийт 3 зөвлөмж хүргүүлснийг Баянцагаан сумын ЗДТГ-ын даргын 2/58 тоот албан бичгээр биелэлтийг ирүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 131,557.4 мянган төгрөгийн 6 зөрчил илэрснээс 1,817.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 32,000.0 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага өгч, 97,470.2 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж хүргүүлэв.

### 4.1 Төлбөрийн акт

1.1. Ажилтан, албан хаагчдын цалинг төрийн албаны нэгдсэн системд амралт бодож олгохдоо 1,817.2 мянган төгрөгийг давхардуулан олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан олгосон 1,817.2 мянган төгрөгийн амралтын цалинг нэр бүхий 5 албан хаагчдаар нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**4.2 Албан шаардлага**

1.1. Тайлант онд шилжиж ирсэн 25.0 сая төгрөгийн үнэ бүхий Лексус-470 маркийн автомашин нь банк бус санхүүгийн байгууллагын нэр дээр эзэмшлийн гэрчилгээтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5.1-д заасан "Төрийн өөрийн өмчид энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад төр эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулж болох дараах эд хөрөнгө хамаарна:", "төрийн байгууллага, албан газарт эзэмшүүлсэн эд хөрөнгө" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Баянцагаан сумын ЗДТГ-т эзэмшүүлсэн Лексус-470 маркийн автомашины эзэмшлийн гэрчилгээг холбогдох хуулийн байгууллагад шилжүүлэн шалгуулж, өөрийн эзэмшлийн нэр дээр шилжүүлэн авах албан шаардлага хүргүүлэв.

1.2. Өмнөх онд зөвлөмжөөр хөрөнгө оруулалтаар ирээд 3 жил болоогүй TLC 200 автомашин засвар үйлчилгээ, зогсоолын төлбөр 8,149.9 мянган төгрөгийг төсвөөс гаргасанд төсөвт буцаан төлүүлж төсөвт учирсан хохирлыг арилгахаар өгсөн байхад тайлант онд шилжиж ирсэн, өөрийн эзэмшилд шилжээгүй хөрөнгөд 7,000.0 мянган төгрөгийн засвар хийж зөрчлийг давтан гаргасан байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлант онд зарцуулсан 7000.0 мянган төгрөг болон өмнөх оны 8149.9 мянган төгрөгийн хохирлыг барагдуулах арга хэмжээг хуулийн байгууллагад өгч шийдвэрлүүлэх албан шаардлага өгөв.

**4.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*

Аж ахуйн материал 565.0 мянга, Түлш шатахууны зардалд 230.1 мянга, бусад хангамжийн материал 550.0 мянга, нийт 1,345.1 мянган төгрөгөөр тайланг зөрүүтэй тайлагнасан байна.

*1.2. <u>Өгсөн зөвлөмж:</u>*

Дутуу тайлагнасан 1,345.1 мянган төгрөгийн тайланг үнэ зөв гаргаж эхний хагас жилд багтаан шалгуулах.

*2.1. <u>Илрүүлэлт:</u>*

Тайлант хугацаанд оруулбал зохих 493,678.8 мянган төгрөгийн үнийн дүнтэй 151 мэдээллийг байршуулахаас 402,170.6 мянган төгрөгийн 116 мэдээллийг хугацаанд нь байршуулсан бол Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 91,507.8 мянган төгрөгийн 35 мэдээг хугацаа хоцроож байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг зөрчсөн байна.

*<u>2.2.</u> <u>Өгсөн зөвлөмж:</u>*

Цаашид Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээг цаг хугацаанд нь байршуулж байх.

3.1. Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 26,986.1 мянган төгрөгөөр, тодотголоор 26,537.0 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 26,476.2 мянган төгрөг зарцуулж Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.8[1] дахь заалтаар 20 хувь буюу 5,397.2 мянган төгрөг хэмнэхээс 509.9 мянган төгрөг буюу 1.2 хувь хэмнэсэн нь тогтоолыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

[1] байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

*3.2. Өгсөн зөвлөмж:*

Цаашид Засгийн газраас төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар гаргасан тогтоол, журмыг хэрэгжүүлэн ажиллах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Баянцагаан сумын ЗДТГ | 6 | 131,557.4 | 0 | 0 | 1 | 1,817.2 | 2 | 32,000.0 | 3 | 97,470.2 |

______oOo______

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА